



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/Н/14

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 67 дугаар дүгнэлтийн дагуу Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлын тендерийн 1 дүгээр багц Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн гадна тохижилт, хөл бөмбөгийн талбай /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлыг 125028598 (нэг зуун хорин таван сая хорин найман мянга таван зуун ерэн найм), 13 дугаар багц 6 дугаар цэцэрлэгийн сантехник, цахилгаан, дотор засал /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлыг 67997338 (жаран долоон сая есөн зуун ерэн долоон мянга гурван зуун гучин найм) төгрөгөөр Баяндөхөмийн хурд ХХК-иар, 2 дугаар багц Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн гадна тохижилт, хөл бөмбөгийн талбай /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлыг 128988695 (нэг зуун хорин найман сая есөн зуун наян найман мянга зургаан зуун ерэн тав) төгрөгөөр Бако констракшн ХХК-иар, 3 дугаар багц Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлыг 50000000 (тавин сая) төгрөгөөр Ихтэнгэрийн илд ХХК-иар, 4 дүгээр багц 1 дүгээр цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлыг 10000000 (арван сая) төгрөгөөр Богдын буян ХХК-иар, 5 дугаар багц 2 дугаар цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлыг 14990000 (арван дөрвөн сая есөн зуун ерэн мянга) төгрөгөөр Буянт хурд ХХК-иар, 14 дүгээр багц 4 дүгээр цэцэрлэгийн дээврийн засвар /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлыг 49695493 (дөчин есөн сая зургаан зуун ерэн таван мянга дөрвөн зуун ерэн гурав) төгрөгөөр Итгэлт-Өргөө ХХК-иар, 15 дугаар багц Сургуулийн дотуур байрны тохижилт, тоног төхөөрөмж /Өвөрхангай, Тарагт сум/ ажлыг 42500000 (дөчин хоёр сая таван зуун мянга) төгрөгөөр Бэлчирконстракшн ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол) нарт тус тус даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100686

D:My Doc. Zahiramj. Zasag darga